

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 25-ны өдөр

№01

Улаанбаатар хот

Компанийн 2017-2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.А хэсгийн 7.8.3 дахь заалт болон 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2017-2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд тус компани өнгөрсөн онд үйл ажиллагааг эхлүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр төсөл боловсруулан, техник технологийн шинэчлэлийн судалгааг хийж, бусдад төлөх өр төлбөрийг төлөх талаар тодорхой ажлуудыг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлж ажилласныг тэмдэглэж “Бөхөг” Хувьцаат компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 25-ны өдөр

№02

Улаанбаатар хот

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.А хэсгийн 7.8.8 дахь заалт болон 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг **Хавсралт**-аар баталсугай;
2. Энэ тогтоол, тогтоолын хавсралтаар баталсан бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ц.Чанцал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

"Бөхөг" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын
тогтоол №02-ын хавсралт



2019 оны 04-р сарын 25-ны өдөр

"БӨХӨГ" ХК-ийн 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажил	2019 он												Хөрөнгө оруулалт	Хариуцах эзэн	Хяналт тавих эзэн	Тайлбар
		5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар								
I Байгууллагын удирдлага зохион байгуулалт																	
1.1	Байгууллагыг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулах, зураг, төлөвлөгөөг хийх													Д Отгонбилэг	Ц Чанцал		
1.2	Удирдлагын чадавхийг сайжруулах ажлыг зохион байгуулах													Д Отгонбилэг	Ц Чанцал		
1.3	Удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох төлөвлөгөөг зохион байгуулах													Д Отгонбилэг	Ц Чанцал		
1.4	Маркетинг менежментийг сайжруулах төлөвлөгөөг зохион байгуулах													Д Отгонбилэг	Ц Чанцал		
1.5	Хөрөнгө оруулалт бизнес төлөвлөгөөг дахин шинэчлэх													Д Отгонбилэг	Ц Чанцал		
1.6	Холбогдох байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн ажиллах													Д Отгонбилэг	Ц Чанцал		
1.7	Шинэ боловсон хүчин судлах													Д Отгонбилэг	Ц Чанцал		
II Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр																	
2.1	Өндөглөгчийн 63000 дэгдээхэй худалдан авах													Д Отгонбилэг	Ц Чанцал		
2.2	Өндөглөгчөөс өндөг авах													Д Отгонбилэг	Ц Чанцал		
2.3	Халдваргүйжүүлэлт, ариутгалын тоног төхөөрөмж захиалга, угсралт													Д Отгонбилэг	Ц Чанцал		
2.4	165000 шувууны тоног төхөөрөмж													Д Отгонбилэг	Ц Чанцал		

2.5	худалдан авах, угсран суурилуулах Шинэ тоног төхөөрөмжид тохирсон эндийг инкубаторт амлуулах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
2.6	Шинэ тоног төхөөрөмжид дэгдээхийг бойжуулах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
2.7	Шинэ тоног төхөөрөмжид өндөглөгч бий болгох																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
2.8	Тэжээлийн шинэ тоног төхөөрөмжүүдийг захиалах, угсран суурилуулах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
2.9	Тэжээл үйлдвэрлэх																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
2.10	Өндөглөгч шувууны байр шинээр барих																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
2.11	Тээвэрлэлтийн машин тоног төхөөрөмжийг худалдан авах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
2.12	Иж бүрэн лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, угсрах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
III	Хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр																				
3.1	Удирдлагыг чадавхжуулах сургалтанд хамруулах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
3.2	Компаний засаглалын давтан сургалтанд хамрагдах (тодорхой чиглэлээр)																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
3.3	Мэргэжлийн байгууллагаас сургалт авах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
3.4	ХААХҮЯ-ны мэдээлэл, сургалтанд хамрагдах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
3.5	Бусад чиглэлийн сургалтанд хамрагдах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
3.6	Шагнал урамшуулал, хариуцлагын журам боловсруулах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
IV	Аж ахуйн чиглэлээр																				
4.1	Хөрөнгийг бүртгэж коджуулах																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
4.2	Цэвэр бохир усны байгууламжийн асуудлыг эцэслэн шийдвэрлэх																		Д Отгонбилэг	Ц Чанцал	
4.3	Гал командын байрны асуудлыг эцэслэн шийдэх																		Д Отгонбилэг	Ц Чанцал	

[illegible]

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 25-ны өдөр

№03

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар

ТУЗ-д эрх олгох эсэх тухай

Монгол улсын омпанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэг, 62.1.10 дахь хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.А хэсгийн 7.7.3 дахь заалт, болон 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой санхүүхийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчидтай их хэмжээний хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгосугай.
2. Их хэмжээний хэлцэл хийхтэй холбоотой ажлыг эрхлэн гүйцэтгэх, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ц.Чанцал/, Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-т тус тус хариуцуулан даалгасугай.
3. Их хэмжээний хэлцэл, түүнтэй холбогдох бүртгэл, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, зохих бичиг баримтыг “Санхүүгийн зохицуулах хороо”, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон бусад холбогдох газруудад хуульд заасан хугацаанд, зохих журмын дагуу бүртгүүлэх, хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 25-ны өдөр

№04

Улаанбаатар хот

Ногдол ашиг тараах эсэх талаархи ТУЗ-ийн тогтоолыг хэлэлцэж батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.Б хэсгийн 7.32.10 дахь заалт, 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2018 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайланг судлан үзсэний үндсэн дээр Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03-р сарын 06-ний өдрийн №02 тоот тогтоолыг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04-р сарын 25-ны өдөр

№05

Улаанбаатар хот

Компанийн гүйцэтгэх захиралыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бөхөг” ХК-ийн гүйцэтгэх захирал Цогт овогтой Ганцэцэгийг үүрэгт ажлаас нь чөлөөлж Довчинжав овогтой Отгонбилэгийг томилон ажиллуулах саналыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд хүргүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ